



МОНГОЛ УЛС

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442273

Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn  
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2023.08.30 № 4/1200

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

297

Г СУМ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА  
ЗАХИРАЛ, ЭРХЛЭГЧ НАРТ

ЗДТГ-ын дарга Д.Ортекмарсал

Тибан бичиг хэрэглүүлийн ажил

Шуудан

2023.09.07

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас жил болгон Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч нарын мэдүүлсэн мэдүүлгийг түүврийн аргаар хяналт шалгалтыг хийж ажилладаг. Хяналт шалгалтыг хийх явцад Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийн үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй" гэж заасныг зөрчиж худал мэдүүлж байгаа нь хуулийн хариуцлага хүлээх үндэслэлтэй болж байна. Тухайлбал:

Мэдүүлэг гаргагч нь холбогдох хуульд заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлэх байтал мэдүүлээгүй ч юмуу эсвэл хугацаа хоцроож мэдүүлсэн мөн Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүйгээсээ болж хариуцлага үүрэх үндэслэл болоод байна.

Иймд дээрх Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөвөөр тогтсон хугацаанд нь мэдүүлж хариуцлагатай ажиллана уу.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Д.САРАНГАРАВ